

2025.06.13-ны өдөр

Баян-Өндөр сум

[illegible]

Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол

2	Тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар авах арга хэмжээний тухай 2024-11-06	1.3.	Төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлж, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг таниулах сургалтыг зохион байгуулж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өргөжүүлж, үр дүнг тайлагнаж ажиллах.	Тайлант оны эхний хагас жилд байгууллагын "Ёс зүйн дэд хороо" нь 2025 онд хийх ажлын төлөвлөгөөгөө байгууллагын даргаар батлуулан ажиллаж байна. Байгууллагын ажилтан, албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд 2 удаагийн сургалтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан.Үүнд: -02 дугаар сарын 03-ны өдөр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн эрх зүйч Б.Алтанзул, М.Эрдэнэт-Од нартай хамтран 2025 онд шинээр даган мөрдөж байгаа хууль, тогтоомжийг сурталчлах сургалтыг зохион байгуулж, 22 албан хаагч хамрагдсан. -05 дугаар сарын 07-ний өдөр аймгийн Хүүхэд, гэрбүлийн хөгжил, хамгааллын газрын мэргэжилтэн Ц.Уянгатай хамтран "Гэр бүл-Харилцаа хандлага" сэдэвт сургалтыг зохион байгуулж, 26 албан хаагчийг тус тус хамруулсан.	70%	-	-
3	ЕЗДБХ. Тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар авах арга хэмжээний тухай 2024-	1.2.	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр" (2024-2030)-ийн хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангаж, жил бүр тайлагнах;	Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд "Ёс зүйн дэд хороо"-ны ажлын төлөвлөгөөг тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Байгууллагын даргын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/52 дугаар тушаалаар "Ёс зүйн дэд хороо" шинэчлэн баталж, 3 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Тайлант онд байгууллагын "Ёс зүйн дэд хороо" нь 11 ажил зохион байгуулахаар	70%	-	-

	11-06			төлөвлөн ажиллаж эхний хагас жилд 7 ажлыг хэрэгжүүлэн ажилласан.			
4	БСШУСБХ. Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021-10-19	1.12/	Нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдийн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх, спортын барилга байгууламж, заал, талбайн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, жил бүрийн улсын төсвийн төсөлд биеийн тамир спортын салбарын зардлыг нэмэгдүүлэх талаар анхаарч ажиллах.	Тайлант оны эхний хагас жилд спорт заалны хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор шинэ спорт цогцолборын зураг, төсөв боловсруулах ажлыг орон нутгийн төсвийн 631,0 сая төгрөгийн хөрөнгөөр гүйцэтгүүлэхээр тендер зарлаж, гүйцэтгэгчээр "Зэд прожект" ХХК шалгаран гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн дагуу хөл бөмбөгийн "Хангардийн залгамж үе" клуб, волейболын "Харх" клубүүдээс спорт заал барих санал ирүүлснийг аймгийн ЗДТГ-н Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст уламжилсан. Аймгийн хэмжээнд төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар спортын заал 3 баригдаж байна. Үүнд: -Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн спортын заал 60%; -Ерөнхий боловсролын 16 дугаар сургуулийн спортын заал 70%; -Хувийн хэвшилд "Зэс эрдэнийн хувь" ХХК-н эзэмшил иргэн н.Мөнх-Амгалангийн хөрөнгө оруулалтаар спортын заалны барилгын ажил гүйцэтгэл 90%.	70%	-	-
5	БСШУСБХ. Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг	1.6/	Биеийн тамирын багш, дасгалжуулагч, арга зүйч, мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, тэдгээрийг гадаад улсад бэлтгэх, мэргэшүүлэх	Тайлант оны эхний хагас жилд дасгалжуулагч, шүүгч бэлтгэх, арга зүйч, мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх 6 удаагийн сургалтад 40 албан хаагч, биеийн тамирын багш нарыг хамруулсан. Үүнд -Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас хяналт-шинжилгээ, үнэлгээний албан хаагчдыг мэргэшүүлэх сургалт 2025	90%	-	-

	хангах зарим арга хэмжээний тухай 2021-10-19		чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	оны 02 дугаар сарын 17-ний өдөр Улаанбаатар хотод Удирдлагын академид зохион байгуулагдаж байгууллагаас 1 албан хаагч; - Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас Хойд бүсийн форумыг 2025 оны 04 дүгээр сарын 26-ний өдөр Орхон аймагт зохион байгуулж, байгууллагаас 8 албан хаагч; -Монголын сагсан бөмбөгийн холбооноос 2025 оны 01 дүгээр сараас 03 сар хүртэл В зэрэглэлийн дасгалжуулагч бэлтгэх сургалтад 2 биеийн тамирын багш, С зэрэглэлийн сургалтад 5 биеийн тамирын багш; -Монголын ахмад мастеруудын нэгдсэн волейболын холбоо Орхон аймгийн Волейболын холбооноос "Волейболын шүүгч бэлтгэх анхан шатны сургалт" 2025 оны 03 дугаар сарын 20-ний өдрөөс 03 дугаар сарын 21-ний өдрүүдэд зохион байгуулагдаж Орхон аймгаас 9 биеийн тамирын багш хамрагдаж батламжаа гардан авсан. -Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооноос 2025 оны 06 дугаар сарын 14-ний өдөр Дархан-Уул аймагт төвийн бүсийн спортын байгууллагуудын биеийн тамирын арга зүйч нарыг чадавхжуулах "Идэвхтэй хөдөлгөөн, эрүүл амьдралын хэв маяг" сэдэвт сургалтад 10 албан хаагч оролцсон.			
6	БСШУСБХ. Биеийн тамир,	1.5/	бүх шатны боловсролын сургалтын байгууллагын биеийн тамирын хичээлийн	Тайлант оны эхний хагас жилд аймгийн хэмжээнд спортын 1 цогцолбор, спортын 36 зааланд биеийн тамир, спортын 25 төрлөөр	90%	-	-

8	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-04-05	1.8.	Иргэд, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудыг дэмжин хамтран ажиллах;	Ерөнхийлөгчийн зарлиг Тайлант оны эхний хагас жилд 115 удаагийн тэмцээн уралдаан, арга хэмжээнд 29,819 иргэдийг хамруулан зохион байгуулсан. Үүнд: -Улсын аварга шалгаруулах тэмцээн 8, бүсийн болон олон хотын аварга шалгаруулах тэмцээн 4, нийт 12 удаагийн тэмцээнд 2867 тамирчин хамруулан зохион байгуулсан. Тэмцээн уралдааныг зохион байгуулахад улс, орон нутгийн төсвийн 43,4 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан.Тэмцээн уралдаанд оролцогч тамирчид худалдаа, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид 300,0 сая төгрөгийн худалдан авалт хийж хувийн хэвшлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн. -Хийн болон эрүүл мэндийн дасгал хөдөлгөөнийг сурталчлан “Хичээллэе-Өрнүүлэе-Хэвшье” аян болон биеийн тамир чийрэгжүүлэлтийн 49 арга хэмжээнд давхардсан тоогоор 12,414 иргэнийг хамруулж улс, орон нутгийн төсвийн 23,6 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан. -Спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор шинээр “Эрдэнэт спортын цогцолбор”-ын зураг төсөв боловсруулах ажлыг орон нутгийн төсвийн 631,0 сая төгрөгийн хөрөнгөөр гүйцэтгүүлэхээр “Зэд прожект” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна. - Спортын хэрэгслийн түрээсийн үйлчилгээнд 4200 иргэн, амралт, чөлөөт цагийн талбайд 5 удаагийн тэмцээн уралдаан, арга хэмжээг	100%	-	-
---	--	------	---	---	------	---	---

				зохион байгуулж, 1409 иргэдийг тус тус хамруулан ажилласан. -Үндэсний спортын 5 төрлөөр 24 удаагийн тэмцээн уралдаанд 3136 тамирчдыг хамруулж, орон нутгийн төсвийн 20,2 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан.			
Хэсгийн дундаж: 100 хувь Засгийн газрын тогтоол							
9	Танилт, нэвтрэлтийн арга, хэрэгсэл батлах тухай 2024-12-18 №217	2.2.	Хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхэд танилт, нэвтрэлтийн системийг ашиглахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга нарт болон төрийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай.	Хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхэд танилт, нэвтрэлтийн системийг ашиглахыг хуулийн хэрэгжилтийн хүрээнд тус байгууллага дараах танилт, нэвтрэлтийн системийг ашиглаж байна. Үүнд: -Esign Клиент Программ ашиглан албан хэрэг хөтлөлтөд тоон гарын үсэг; -Албан хаагчдын цаг бүртгэлийн системд Биометрик өгөгдөл; -Байгууллагын төсвийн зарцуулалтад Банк, банк бус санхүүгийн байгууллагын баталгаажсан эрх ашиглан нэг удаагийн нууц үгээр;	100%	-	-
10	Жуулчдын урсгалыг нэмэгдүүлж, дөрвөн улирлын турш жуулчин хүлээн авах зорилтын хүрээнд хэрэгжүүлэх	2.3.	Аялал жуулчлалын нэгдсэн цаглабрыг боловсруулж, улирлын онцлогийг харгалзан салбарын олон улсын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, урлаг, соёл, спортын зарим арга хэмжээг жил бүрийн 10 дугаар сараас дараа жилийн 4 дүгээр сар хүртэл хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөж ажиллахыг	Тайлант оны эхний хагас жилд аймагтаа улсын аварга шалгаруулах тэмцээн 8, бүсийн болон олон хотын аварга шалгаруулах тэмцээн 4, нийт 12 удаагийн тэмцээнд 2867 тамирчин хамруулан зохион байгуулсан. Тэмцээн уралдааныг зохион байгуулахад улс, орон нутгийн төсвийн 43,4 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан.Тэмцээн уралдаанд оролцогч тамирчид худалдаа, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид 300,0 сая төгрөгийн худалдан авалт хийж,	100%	-	-

	зарим арга хэмжээний тухай 2024-11-27 №191-1		Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт.	хувийн хэвшлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн.			
11	Төрийн байгууллагын үйл ажиллагааны цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2024-11-13 №163	2.	Төрийн захиргааны байгууллагын албан хэрэгцээнд ашиглах баримт бичиг боловсруулах программ хангамжийн лицензийг Ерөнхий гэрээгээр худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу нэгдсэн журмаар зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд Т.Доржхандад, холбогдох зардлыг төсвийн багцдаа тусган санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус үүрэг болгосугай.	Байгууллагын албан ажлын хэрэгцээнд и-оффис программ хангамжийг ашиглан цахимаар баримт бичиг боловсруулах, баталгаажуулах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%	-	-
12	Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай 2024-10-02 №109-1	2.	Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолын хавсралтаар баталсан ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн батлан хэрэгжүүлэх, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай	Биеийн тамир, спортын газрын "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ийг 2024 оны 04 дүгээр сарын 05-ний өдөр байгууллагын даргаар батлуулан мөрдөн ажиллаж байна. Ёс зүйн дэд хорооны гишүүдэд байгууллагын даргын тушаалаар улирал бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 40%-ийн урамшуулал олгож байна.	100%	-	-
13		3.	"Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих	Төрийн албаны "ХНУМТ" цахим системийг ашиглан байгууллагын төрийн албан хаагч	100%	-	-

	Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим системийн талаар авах арга хэмжээний тухай 2024-05-08 №196		цахим систем"-ийг ашиглан эрхлэх асуудлынхаа хүрээндээ төрийн албан хаагчийн мэдээллийн бүрдүүлэлт, үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай	29, гэрээт ажилтан 5 хүний мэдээллийг оруулж, 29 төрийн албан хаагчид мэдээллээ шалган цахимаар баталгаажуулан ажиллаж байна.			
14	Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-12-20 №196	2.	Төлөвлөгөөнд тусгагдсан, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.(Өвлийн аялал жуулчлалын 2024 оны төлөвлөгөө) Төлөвлөгөө батлагдсанаас хойш хэрэгжилтийг тайлагнах	Тайлант оны эхний хагас жилд өвлийн спорт аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор аймагтаа улсын аварга шалгаруулах тэмцээн 4, олон хотын болон аймгийн аварга шалгаруулах нээлттэй 3 тэмцээнийг зохион байгуулж, 849 тамирчдыг хамруулсан.Үүнд: -Монголын үндэсний Мөсний шагайн шилдэг багуудын аварга шалгаруулах "Эрдэнийн цом" Тэмцээнд 8 аймгийн 35 багийн 210 харваач; -"Мөрөөдлийнхөө төлөө-Шударгаар өрсөлдье" урианы дор Монголын Хүүхдийн спортын өвлийн VIII наадмын цанын спортын 4 төрлийн тэмцээнийг Сархиа цанын баазад зохион байгуулж, тэмцээнд 13 аймаг, 6 дүүргийн 209 тамирчин; -Гүйлтийн цанын насанд хүрэгчдийн 2025 оны улсын аварга шалгаруулах тэмцээнд 10 аймаг, 4 дүүргийн 110 тамирчин;	100%	-	-

				-Авто спортын "Ice drift-2025" улсын аварга шалгаруулах тэмцээнд 5 аймаг, дүүргийн 50 гаруй тамирчид; Мөсний сурын харвааны аймгийн аварга шалгаруулах нээлттэй тэмцээнд 6 аймгийн 70 харваач; -Эрдэнэт мөнгөн өвөл-2025 аяны хүрээнд гүйлтийн цанын өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах нээлттэй тэмцээнд 10 аймаг, 2 дүүргийн 100 гаруй тамирчид; -Гүйлтийн цанын "Клубүүдийн аварга шалгаруулах тэмцээн"-д 8 аймаг, 2 дүүргийн 100 гаруй тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин уралдсан.			
Хэсгийн дундаж: 100 хувь							
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл							
15	Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдааны 31 дүгээр тэмдэглэл	31.9.6.2/	Төрийн байгууллагын "gov.mn" нэгдсэн цахим хуудаст мэдээллийг байршуулах, тухай бүр шинэчлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	Төрийн байгууллагын "gov.mn" нэгдсэн цахим хуудаст байгууллагын orkhon.sport.gov.mn цахим хуудсыг холбосон. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд зааснаар байгууллагын мэдээ мэдээллийг orkhon.sport.gov.mn-д бүрэн байршуулсан.	100%	-	-
Хэсгийн дундаж: 100 хувь							
Засгийн газрын албан даалгавар							
16	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн	1.13.	Аймаг, нийслэлийн хэмжээнд идэвхтэй хөдөлгөөн, эрүүл хооллолтыг хэвшүүлэх, биеийн тамирын дасгал сургуулилтаар хичээллэх	Тайлант оны эхний хагас жилд аймгийн хэмжээнд хийн болон эрүүл мэндийн дасгал хөдөлгөөнийг сурталчлан "Хичээллэе-Өрнүүлэе-Хэвшье" аян болон биеийн тамир чийрэгжүүлэлтийн 49 арга хэмжээнд давхардсан тоогоор 12,414 иргэнийг	70%	-	-

	хэрэгжилтийг эрчимжүүлэх тэй холбогдуулан 2025 оны эхний хагаст орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2025-03-07 №03		боломж, хүртээмжийг нэмэгдүүлэх;	хамруулж, улсын төсвийн 12,2 сая төгрөг, орон нутгийн төсвийн 11,4 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан.		
17	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тэй холбогдуулан 2025 оны эхний хагаст орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2025-03-06 №03	1.24.	Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах;	Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангаж тайлант оны эхний хагас жилд 115 удаагийн тэмцээн уралдаан, арга хэмжээнд 29,819 иргэдийг хамруулан зохион байгуулсан. Үүнд: -Улсын аварга шалгаруулах тэмцээн 8, бүсийн болон олон хотын аварга шалгаруулах тэмцээн 4, нийт 12 удаагийн тэмцээнд 2867 тамирчин хамруулан зохион байгуулсан. Тэмцээн уралдааныг зохион байгуулахад улс, орон нутгийн төсвийн 43,4 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан.Тэмцээн уралдаанд оролцогч тамирчид худалдаа, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид 300,0 сая төгрөгийн худалдан авалт хийж хувийн хэвшлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн. -Хийн болон эрүүл мэндийн дасгал хөдөлгөөнийг сурталчлан “Хичээллэе-Өрнүүлэе-Хэвшье” аян болон биеийн тамир	70%	-

чийрэгжүүлэлтийн 49 арга хэмжээнд давхардсан тоогоор 12,414 иргэнийг хамруулж улс, орон нутгийн төсвийн 23,6 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан.

-Спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор шинээр "Эрдэнэт спортын цогцолбор"-ын зураг төсөв боловсруулах ажлыг орон нутгийн төсвийн 631,0 сая төгрөгийн хөрөнгөөр гүйцэтгүүлэхээр "Зэд прожект" ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна.


-Спортын хэрэгслийн түрээсийн үйлчилгээнд 4200 иргэн, амралт, чөлөөт цагийн талбайд 5 удаагийн тэмцээн уралдаан, арга хэмжээг зохион байгуулж, 1409 иргэдийг тус тус хамруулан ажилласан.

Хэсгийн дундаж: 70 хувь

Нийт дундаж: 85 хувь

ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНАСАН:


БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА



Д.ДЭЛГЭРБАЯР

ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



М.АРИУН-ЭРДЭНЭ